



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 6 нэрийн, нийт 31,775,153.86 (гучин нэгэн сая долоон зуун далан таван мянга нэг зуун тавин гурван төгрөг наян зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 8,730,000.00 (найман сая долоон зуун гучин мянган) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Төгөлдөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг бөлгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13 000 5000
12-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 05 дугаар сарын ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт

СҮХБААТАР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөгөөр)		
							Цаашид ашиглах хугацаа /жилээр/	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Компьютер /Dell Optiplex 7040/ Сумдын даамал	12/3/2016	9	ш	2,299,000.00	20,691,000.00	3	600,000.00	5,400,000.00
2	Принтер /Samsung M7020/ Сумдын даамал	12/3/2016	12	ш	299,000.00	3,588,000.00	3	90,000.00	1,080,000.00
3	Компьютер /Dell Optiplex 7020/	12/31/2014	1	ш	2,113,154.86	2,113,154.86	3	640,000.00	640,000.00
4	Зөврийн компьютер /Dell inspiron 3568 Laptop i5/	12/22/2017	1	ш	1,534,000.00	1,534,000.00	3	460,000.00	460,000.00
5	Айпад /Ipad apple MD 368LL/A64 GB	9/2/2013	1	ш	2,348,999.00	2,348,999.00	3	700,000.00	700,000.00
6	Компьютер /Dell Optiplex 7010/	12/16/2013	1	ш	1,500,000.00	1,500,000.00	3	450,000.00	450,000.00
			25		10,094,153.86	31,775,153.86		2,940,000.00	8,730,000.00
	НИЙТ ДҮН		(хорин тав)		(арван сая ерэн дөрвөн мянга нэг зуун тавин гурван төгрөг наян зургаан мөнгө)	(гучин нэгэн сая долоон зуун далан таван мянга нэг зуун тавин гурван төгрөг наян зургаан мөнгө)		(хоёр сая есөн зуун дөчин мянга)	(найман сая долоон зуун гучин мянга)